

## **МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

### **НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 69 ажил, арга хэмжээг төлөвлөж, 97.8 хувийн үнэлгээтэй дүгнэж, нийт 47 зүйл, 83 заалт бүхий баримт бичгийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр, 9 баримт бичгийн биелэлтийг сар тутам Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газарт тайлагнасан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас болон Тэргүүн дэд, Дэд, Захиргааны удирдлагын газрын дарга буюу дээд шатны байгууллага албан тушаалтнаас нараас цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан албаны үндсэн үйл ажиллагаанд чиглэсэн 141 удаагийн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж ирүүлснийг хэрэгжилт үр дүнг 100 хувь тооцон ажилласан.

Албаны даргаас харьяа нэгжийн дарга, алба хаагчдад “Үүргийн биелэлт тооцох хуудас”-аар 27 удаа 129 үүрэг хүргүүлж, хэрэгжилт 83.0 хувьтай байна.

Тус алба нь энэ онд 1,9 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 1,7 тэрбум ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 41,8 сая байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 4,6 сая хангамж бараа материалын зардалд 104,8 сая, тэтгэмж, урамшуулалд 31,2 сая,

урсгал засвар, хичээл сургалт, төлбөр хураамжид 42,6 сая төгрөг зарцуулсан.

Албаны хэмжээнд эд хөрөнгийн бүртгэлийг дансанд бүртгэлтэй нийт 1165 эд хөрөнгийн бүртгэлийг QR код руу, 971 бараа материалыг Barcode руу хөрвүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

### **ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ:**

Албаны хэмжээнд хүний нөөцийн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх, алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, шатлан дэвшүүлэх зарчим, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/”, “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах /код 908/”, “Албан тушаал дэвшүүлэх /код-909/” журмуудыг баримтлан албаны харьяа нэгжээс алба хаагчийг томилуулах, дэвшүүлэх, шилжүүлэх, чөлөөлөх, шагнуулахаар ирүүлсэн саналын дагуу 2022 онд томилгооны 405, цол, шагналын 340, нийт 745 саналыг хүлээн авч шийдвэрлэв.

Тус албанаас цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд “Мэргэжлийн зэрэг олгох шалгалт”-д алба хаагчдыг хамруулж, хууль эрх зүйн шалгалтад 158, бие бялдрын шалгалтад 131 алба хаагч хамрагдаж, “Цагдаагийн мэргэжлийн зэрэг”-ийг 40 алба хаагч ханган тэнцсэн.

Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор энэ онд 86 удаагийн 89 цагийн сургалтад давхардсан тоогоор 15680 алба хаагчийг хамруулсан.

Мөн соён гэгээрүүлэх 208 ажил зохион байгуулж давхардсан тоогоор 41543 алба хаагчийг хамруулсан.

### **ГУРАВ. АЛБА ХААГЧДЫН САХИЛГА, ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТАЛААР**

Энэ онд тус албанаас 68 сахилгын зөрчилд 63 алба хаагч холбогдсоноос 48 буюу 70.5 хувийг офицер, 20 буюу 29.4 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байгаа нь урьд оны үетэй харьцуулахад 18 хувиар буурсан.

Сахилга, ёс зүйн зөрчлийн хэлбэрийг урд оны мөн үетэй харьцуулбал ажлын хариуцлага алдсан зөрчил 55.5 хувиар өсөж, архидан согтуурсан зөрчил 32 хувиар буурсан байна.

### **ДӨРӨВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Дүн шинжилгээ, судалгааны хэлтсээс шинээр 3 программ хангамж нэвтрүүлж, 2 ажил шинээр санаачлан хэрэгжүүлж, судалгаа, дүн шинжилгээний 55 ажил хийж гүйцэтгэн, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулга, мэдээлэл 278-ыг хүргүүлсэн байна. Тухайлбал:

Улсын хэмжээнд болон аймаг, дүүрэг тус бүрд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн суурь үзүүлэлтээр, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, бие бүрэлдэхүүн, хүний нөөц, техник хэрэгслийн талаар, Монгол Улсад бүртгэгдсэн жагсаал, цуглаан, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын нөхцөл байдал зэрэг сүүлийн 10-12 жилийн статистик мэдээлэлд тулгуурлан нийт 10 мянган гаруй хувьсагч параметр, 12 сая дата мэдээлэлд үндэслэн, 2023-2030 он хүртэлх ирээдүйн төлөв байдлыг тооцон гаргасан.

Энэхүү системийн динамик загварын зохиогчийн эрхийг Оюуны өмчийн газарт бүртгүүлж, албан ёсны зохиогчийн эрхийн гэрчилгээг “Цагдаагийн ерөнхий газар”-ын нэр дээр авч, хууль зүйн салбарын хэмжээнд “Системийн динамик загвар”-ыг нэвтрүүлсэн анхны агентлаг болсон.

“Дүн шинжилгээ, судалгааны цахим сан” буюу “research.police.gov” программ хангамжийг шинээр нэвтрүүлснээр 74 алба, нэгжийн 302 мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 4033 алба хаагч хандалт хийж, мэдээлэл солилцож ашигласан.

Гэмт хэрэг, зөрчлийн статистик тоон мэдээнд тулгуурлан нөхцөл байдлын графикан мэдээ гаргах “Power bi” программ хангамжийг боловсруулан, сүүлийн 10 жилд бүртгэгдсэн нийт гэмт хэрэг болон хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт, хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар, гэмт хэргийн хохирогч, холбогдогчийн мэдээллээр сан үүсгэн судалгаа, танилцуулгад ашиглахад бэлэн болгоод байна.

“Максима” судалгааны байгууллагатай хамтран “Цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцөл боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлага” сэдэвт судалгааг хийж, цагдаа, дотоодын цэргийн 68 анги, байгууллагын 1110 алба хаагчийг хамруулсан.

“Дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Төрийн болон албаны нууцын тухай ойлголт анхаарах асуудал” гарын авлагыг Цагдаагийн байгууллагын нэгдсэн системд байршуулсан.

“Дүн шинжилгээнд суурилсан цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт” эмхэтгэлийг Цагдаа, дотоодын цэргийн 78 анги байгууллагын албан хэрэгцээнд ашиглуулахаар нийт 150 ширхгийг хүргүүлсэн.

### **ТАВ. МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭХ, ЛАВЛАГАА ОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:**

-Цагдаагийн байгууллагын гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санг 34 төрлийн 3.442.614 нэгж мэдээллээр баяжуулж, лавлагааны сангаас 24,817 хүн, 374 хуулийн этгээдийн лавлагаа олгосон байна.

“Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2021 он”товхимлыг нутаг дэвсгэрээр болон тодорхой төрлийн гэмт хэргийн өнгөөр нь боловсруулж, 200 ширхгийг хэвлүүлэн, Оюуны өмчийн газраас 13763 дугаар бүхий гэрчилгээгээр баталгаажуулав.

“Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал” товхимлуудыг цахим хэлбэрт шилжүүлж, олон нийтэд нээлттэйгээр хүртээх, цахим номын сан үүсгэх ажлыг эхлүүлээд байна.

Улсын Ерөнхий Прокурор, цагдаагийн байгууллагын хооронд цахим мэдээллийг харилцан солилцох, цахим гарын үсгээр баталгаажсан албан бичгийг үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор 2 байгууллагын хэмжээнд ашиглагдаж буй архив, албан хэрэг хөтлөлтийн тус тусын программыг төрийн мэдээллийн сүлжээгээр дамжуулан харилцан ашиглах ажлыг эхлүүлсэн.

### **ЗУРГАА. ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг, зөрчил, цар тахлын мэдээг улсын хэмжээнд нэгтгэн, танилцуулгаар 365 удаа, онцлог мэдээ мэдээлэл 1184 удаа, цаг үеийн нөхцөл байдлын мэдээг 26556 удаа мессежээр Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад, Хоногийн эрүү, хэв журмын нөхцөл байдлын мэдээллийг **extranet.nsc.mn** хаягт байршуулсан өгөгдлийн дагуу 365 удаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд цахим хэлбэрээр танилцуулж, шуурхай байдлыг хангаж ажилласан.

“Хаан шонхор-2022” дадлага, сургуулийн бэлтгэл ажлыг хангаж, Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын штабыг явуулын байдлаар ажиллуулж, “Сөргө-2022” стратегийн команд штабын нэгдсэн дадлага, сургуулилтын бэлтгэл ажлын хүрээнд Шуурхай удирдлагын штабын “Удирдлагын баг”-т удирдах албан тушаалтан 13, штабт 17 алба хаагч үүрэг гүйцэтгэж ажилласан.

Штаб бүрэн бүрэлдэхүүнээр 28 удаа давхардсан тоогоор 338 алба хаагч ажилласан байна.

### **ДОЛОО. МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЭВТРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны А/314 дүгээр тушаалаар тус албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Мэдээллийн технологийн хэлтсийн бүтцэд “Систем хөгжүүлэлтийн тасаг”-ийг шинээр байгуулж, цагдаагийн байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа бүх систем, сервер, сторэйж, галт хана гэсэн нийт 89 тоног төхөөрөмж, тус тусдаа үүрэг зориулалт бүхий 100 гаруй мэдээллийн систем, өгөгдлийн сангийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

“Үндэсний дата төв” УТҮГ, Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран төрийн үйлчилгээний “E-Mongolia” системд 3 төрлийн үйлчилгээг линкээр холбох ажлыг хэрэгжүүлсэн.

Энэ онд шинээр 9 программ хангамжийг боловсруулан үйл ажиллагаанд нэвтрүүлж, 24 программ хангамжид нэмэлт өөрчлөлт, засвар оруулсан. Тухайлбал:

“Тээврийн хэрэгслийн цахим сан” программ хангамжийг боловсруулж Авто баазад, “Дуудлага хяналтын систем”, “ECS таблет”, “Police SOP”, “ECS notification”, “Daily.police.gov” программ хангамжийг шинээр болон нэмэлт өөрчлөлт, боловсруулалт хийж хөгжүүлэн Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Мөрдөн шалгах газарт хүлээлгэн өгсөн.

“Хүүхдийн бүртгэлийн программ хангамж”, “Нэгдсэн хайлт системд шинэчлэл хийж, “Авто сургуулийн систем”, “Жолоочийн шалгалтын систем”, “Жолоодох эрх олгох систем” системүүдийг шинээр боловсруулж, үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн.

Архив, албан хэрэг хөтлөлтийн /eArchive.police.gov/ программ хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд уг программыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн 98 анги, байгууллагын 1008 хэлтэс, тасаг, хэсэг, 1503 албан тушаалтан өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж, дотооддоо ирсэн бичиг 195643, явсан 83479, өргөдөл, гомдол 1467, төрийн бусад байгууллагаас нийт 2293 албан бичиг хүлээн авч, 6627 албан бичиг явуулж, 11534 файлыг солилцсон байна.

Цахим мэдээллийн аюулгүй байдлын хэлтсээс Цагдаагийн байгууллагын домэйн сүлжээнд холбогдсон төхөөрөмжүүдэд илэрсэн вирусийн тайланг боловсруулж, "virusreport.police.gov"-д байршуулсан.

"Системийн эмзэг байдлыг илрүүлэх Nessus tenable" программ хангамжийг нэвтрүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, цагдаагийн байгууллагын мэдээллийн сүлжээ, системийн эмзэг байдлыг илрүүлэх үйл ажиллагаанд ашиглаж байна.

Бэлэн бус торгуулийн 277 төхөөрөмжийг бүртгэлжүүлж, хэвийн үйл ажиллагаанд оруулж, Цахим гарын үсгийн 134 төхөөрөмжийн мэдээллийг өөрчилж, Хэрэглэгчийн хандах эрх, нууц үгийн удирдлагын нийт 2860 удаагийн хүсэлтийг шийдвэрлэсэн.

Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2022.05.13-ны 3/199 дүгээр албан бичгээр үүрэг, ажлын чиглэлийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлж, энэ оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 11051 алба хаагч, ажилтан буюу 98.8 хувь тоон гарын үсгээ авсан.

Холбооны хэлтсээс алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас засвар, үйлчилгээ хийлгүүлэхээр ирүүлсэн хэт богино долгион гар станц 585, автомашины станц 95, суурин станц 23, дахин дамжуулах станц 6, тусгай дуут гэрэл дохио 22, бусад 8, нийт 739 техник хэрэгслийг хүлээн авч засварлан хэвийн ажиллагаанд оруулж, Цагдаагийн ерөнхий газрын төв байр болон харьяа алба, нэгжээс ирүүлсэн 2049 дуудлагыг хүлээн авч, шийдвэрлэж, ЦЕГ-ын даргын удирдлага, алба нэгжээс зохион байгуулсан нийт 322 хурал, цахим сургалтуудын үеэр дуу, дүрсний техник хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа.

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны "Хаан шонхор-2022" гурав дахь удаагийн нэгдсэн дадлага сургуулилт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас зохион байгуулсан "Сөргө-2022" стратегийн команд штабын нэгдсэн сургуулилт, Төрийн өндөр, дээд хэмжээний гадаад орны зочид төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлалын үе, Үндсэн хуулийн шүүх, түүнтэй адилтгах байгууллагуудын Азийн Нийгэмлэгийн 5 дугаар Их хурал болон Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдах "ХМФ" арга хэмжээ, Канад улсын Парламентын сенатын танхимын дарга Жорж Ж.Фюри Монгол Улсад албан ёсны айлчлал зэрэг төрийн өндөр дээд айлчлал, томоохон арга хэмжээний үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний зохицуулалт хамгаалалтын холбоо зохион байгуулсан.

Тусгай шуудангийн үйлчилгээг 3374 богц буюу 20934 бичиг 454 боодол дагавар солилцон ажиллаж, алба, нэгж хариуцсан цагдаагийн байгууллагад 15005, яаралтай 1008, онц чухал нууц, маш нууц, нууцын 688, нийт 16701 албан бичгийг байгууллага, албан тушаалтанд бүртгэлээр хүлээлгэн өгч ажилласан.

## **НАЙМ. МЭДЭЭЛЭЛ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Гал түймэр, гамшиг, ослын талаарх 4225, гэмт хэрэг, зөрчлийн талаарх 515054, эмнэлгийн яаралтай тусламжийн талаарх 307504, нийт 826783 дуудлага, мэдээллийг хүлээн авч бүртгэн, холбогдох газруудад мэдээллийг дамжуулж, Шуурхай удирдлагын ажил хариуцсан нэгж хооронд шилжүүлэн хяналт тавьж ажилласан байна.

Иргэдээс ирүүлсэн дуудлага, мэдээллийн дагуу үүрэг гүйцэтгэж байгаа цагдаа, онцгой байдал, эмнэлгийн алба хаагчдад хяналт тавих, дуудлага өгсөн иргэнд мэдээлэл өгөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор гал унтраах болон эмнэлгийн түргэн тусламжийн автомашинуудад суурилуулсан GPS системийг ICT компанитай хамтран хянадаг болсон.

Шуурхай удирдлагын танхимд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажлыг хөнгөвчлөх зорилгоор үүрэн холбооны дугааруудыг интернэт дугаараар сольж, алба хаагчид дотуур холбооны IP телефон утсаа ашиглан гарах дуудлага хийх, нэг дугаараар мэдээлэл хүлээн авагч нар зэрэг дуудлага хийх, ярианы бичлэгийг хадгалах боломжийг бүрдүүлсэн.

Хаяг байршлыг тодорхойлох “3 үгт” хаягийн [www.what3words.com](http://www.what3words.com) веб хуудсанд хандах сүлжээний тохиргоог мэдээлэл хүлээн авах суурин компьютеруудад хийсэн.

Төвийн дотоод сүлжээнд ашиглагдаж байгаа хамгаалалтын /*firewall*/ төхөөрөмжийн виртуал тохиргоо, MAC IP тохиргоог хийж, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан.

Байгалийн болон бусад давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр дуудлага мэдээлэл бүртгэн дамжуулах программ хангамж, мэдээллийн сан устах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нөөц сервер байршуулах тухай гэрээг Үндэсний дата төвтэй байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Техник ашиглалтын хэлтсээс техникийн 530 үзлэг, үйлчилгээ, 430 засвар, 447 өргөтгөл суурилуулалт хийж EIN системийн тогтвортой ажиллагааг хангаж ажилласан.

Шуурхай удирдлагын хэлтсүүдийн мэдээлэл хүлээн авагчийг алсын зайнаас буюу ажлыг байрнаас өөр орчноос ажиллах, дуудлага, мэдээллийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн сервер, программ хангамжийн зохион байгуулалт, тохиргоог хийж гүйцэтгэн төвийн үндсэн үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн.

Үндэсний дата төвийн төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын сервисийг ашиглах хүсэлтийг тус төв рүү хүргүүлж, холбогдох эрх, зөвшөөрөл, токенийг цахимаар хүлээн авч, дуудлага, хүлээн авах программыг тоон газрын зургийн системтэй холбож, Улаанбаатар хотын газрын зураг, хаягжилтын системийг ашиглах боломжийг бүрдүүлсэн.

“EIN-GIS” программ дахь цахим газрын зургийн хаягийн мэдээллийг шинэчлэх зорилгоор Нийслэлийн хот төлөвлөлт хөгжлийн газраас нийслэлийн нийтийн эзэмшлийн 12 давхаргын тоон газрын зураг болон Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас 2022.03.31-ний байдлаар гаргасан нийслэлийн 9 дүүргийн хороо, албан байгууллага, айл өрхийн 471.673 ширхэг хаягийн мэдээллийг авч “ArcGis” программ дээр засварлаж, “EIN GIS” программд оруулж мэдээлэл хүлээн авах ажиллагаанд ашиглаж байна.

Тусгай дугаарын утсанд ирж буй дуудлагын ярианы бичлэгийг автоматаар текст хэлбэр рүү шилжүүлдэг “Чимэгэ системс” ХХК-тай хамтран программ боловсруулж дэвшилтэт технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлийн тохиолдлыг баримтжуулах, түүнээс урьдчилан сэргийлэх, иргэнд заавар зөвлөгөө мэдээлэл өгөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор тусгай дугаарын 102 утсанд дуудлага, мэдээлэл ирүүлсэн иргэний гар утасны камерын дүрсийг харж, иргэнтэй харилцах технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, иргэдийн өөрсдийн зөвшөөрсний дагуу интернэт сүлжээний тусламжтайгаар дүрст дуудлага хийх, мэдээлэл хүлээн авах нөхцөл боломжийг бүрдүүлж, энэ оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлснээс хойш 30 иргэнээс дүрст дуудлага хүлээн авч ажилласан шинэлэг ажлуудыг нэвтрүүлсэн байна.

## **МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА**